

**Зарим монгол овгийн үүсэл,
тархац, нэрийн тухай**

*Доктор /PhD/, профессор А.Очир
/ШУА-ийн түүхийн хүрээлэн/*

Монголчуудын угсаатны бүрэлдэхүүнийг судлах нь тэдний уг гарвалыг тодорхойлоход нэгэн түлхэц болох юм. Бид сүүлийн хориод жилд Монгол улсын монголчуудын дотор угсаатны хээрийн судалгаа явуулан, тэдний овог, аймгийн бүрэлдэц, тархацын тухайт мэдээг сурвалжлан хуримтлуулахын зэрэгцээ мөнхүү манай улсын архивуудын сан хөмрөгт хадгалагдан буй холбогдох эх хэрэглэгдэхүүнийг бололцооны хирээр олж үзэхийг хичээж байна. Урьд эрдэмтдийн болон сүүлийн үеийн судалгааны үр дүнд өдгөө Монгол улсын монголчуудын дотроос нэгэн мянга орчим овог, аймгийн нэр илэрч мэдэгдээд байна. Энэхүү овог, аймаг, үржвэрүүдийн угсаа хамаадал, тархалтыг тодорхойлох нь нийт монголчуудын угсаатны түүхийг шинжлэхэд зохих ач холбогдолтой нь мэдээж билээ.

Энэ бяцхан өгүүлэлд, бид хэдэн монгол овгийн тархац, гарал үүсэл, нэрийн тухай товч өгүүлье.

Огниуд, онниуд, онглигууд. Энэ овгууд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Төмөрбулаг, Бүрэн; Дорноговь аймгийн Мандах, Хөвсгөл, Хатанбулаг; Дорнод аймгийн Халхгол; Дундговь аймгийн Өлзийт, Хулд, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Луус, Дэрэн, Өндөршил; Өвөрхангай аймгийн Баян-Өндөр, Сант, Баянгол; Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Баяндалай, Ноён, Сэврэй суманд оршин сууж буй нь мэдэгдсэн¹.

Халхын аман ярианд, гол төлөв огниуд хэмээн дууддаг эл угсаатны нэрийг монгол бичгийн ном зохиолд, *ongniyud* буюу *ongliyud* хэмээн тэмдэглэсэн нь тохиолдоно.

Ongniyud нь угтаа хятад хэлний ван гэдэг үгээс үүсэлтэй. Анхандаа *wang+nu□ud* хэмээн дуудсан нь яваандаа *Ongniyud* болсон байна. Тэр *Ongniyud* нь аман ярианд мөнхүү онниуд (*wang+nuхud→ongnuхud→ongniхud→ongniud→ogniud*) гэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, хятад хэлний ван хэмээх үгэнд монгол хэлний *nuхud* (нугууд) нөхцөл залгаж үүсгэсэн угсаатны нэр хувьссаар огниуд, онниуд буюу болжээ.

Онниуд буюу огниудыг бас заримдаа онглигууд хэмээнэ. Энэ нь мөн л хятад хэлний *wang* гэдэг үгэнд –лиг- нөхцөл залгаж, түүний дээр олны *ud*(-ууд) нэмэн зүүж үүсгэсэн нэр (*wang+liy+ud→wangliyud→ongliyud*) юм.

Ongliyud, ongniуud, ogniud хэмээх үгс нь чухамдаа бол угсаатны нэгэн нэрийн хэдэн хувилбар ажээ. Энэ нэрс хятад хэлний *wang* гэдэг үгтэй холбоотой үүссэн нь цаанаа учиртай юм.

Энэ аймгийн эзэд нь Чингис хааны дүү Отчигин, Хачиун нар юм. Монголын Юань улс (1260-1368)-ын үед Чингис хааны эл дүү нар ван цолтой байв. Тиймээс тэднийг вангууд, ванлигууд хэмээн дууддаг байж. Тэрхүү эзэн ноёных нь цол хэргэм яваандаа тэдний харьяат аймгийн нь нэр болж хувирсан байна. Тиймээс энэ аймгийн нэр хятад хэлний *wang* хэмээх үгтэй холбогджээ.

Зарим сурвалжийн мэдээгээр, Чингис хаан XIII зууны эхэн үед өөрийн дүү Отчигинд килингут (хилингүд А.О.), бэсүд, жадарад (жадаран А.О) нараас голлон бүрдсэн 4000 гаруй өрх; Хачиун, түүний хүү Элжигидэйд 3000 өрх өгсөн ажээ². Харин хожмын мэдээгээр бол, Отчигины үрс Үжэйд (үжээд А.О.), Муйл, Мулсун, Хачиуны үр сад нь Хэхэдэй, Бэлжүдэй, Харцэриг зэрэг аймгийг мэдэж явсан гэнэ³. Тиймээс өдгөөгийн онгниуд буюу онниуд нар нь дээрх аймаг, овгуудаас бүрэлдэн буй болсон гэлтэй байнам.

Отчигин, Хачиун нарын хойчсын захирсан тэрхүү аймгууд Юань улсын эцэс үеэс Онниуд буюу Онглигуд нэрийн дор явах болсон ажээ. Дээрх хоёр ноён болон тэдний үр хойчсын эзэмшил аймаг нь XIII зуунаас эхлэн Хөлөн, Буйр нуураас зүүн тийш, Их Хянганы нурууны баруун хэсэг, Шар мөрөн, Лууха гол хавиар нутагладаг болжээ.

Монголын Юань улс унасны дараа хэсэг хугацаанд Онниуд буюу Онглигуд аймаг нь Хятад улсын эрхшээл нөлөөг хүлээж, Хянганы нурууны баруун биед байсан Тайнин харуулд сууж, XIV зууны эцэс XV зууны эхэн үед Мин улсын хилийг харгалзаж байжээ⁴. XV зууны дунд үеэс тэд баруун тийшлэн, улмаар Цахар түмний бүрэлдэхүүнд багтжээ. Лигдэн хаан Хөхнуур руу нүүдэллэсний дараа Онниуд аймгийн зарим нь 1632 онд, нөгөө хэсэг нь түүнээс хойш удалгүй Манж Чин улсын эрхшээлд оржээ. Манжийн эрх баригчид тэднийг хоёр хошуу болгон зохиогоод, Өвөр Монголын Зуу-удын чуулганд багтаан захируулжээ.

Онниуд хоёр хошууг зүүн, баруун гар хэмээн ялгах бөгөөд зүүн гарын хошуу нь Шар мөрөн, Лууха голын хоорондох нутагт, баруун гарын хошуу нь Жэхэ-гийн ав хоморгоны газрын зүүн хойно, Лууха голын өмнөд этгээдэд нутагласан нь одоо ч тэндээ суусаар байна. Энэхүү Онниуд нарын зарим нь Халх түмний бүрэлдэхүүнд орж явсан байна. Тэд өдгөөгийн Халх, Хотгсйдын доторх огниуд овогтон болжээ.

Дайртан. Энэ овог Монгол улсын Завхан аймгийн Нөмрөг, Тэлмэн, Булнай, Их-Уул; Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр, Галт, Жаргалант; Архангай аймгийн Жаргалант, Тариат, Хангай, Чулуут, Батцэнгэл; Булган аймгийн Хутаг-Өндөр, Баян-Агт; Төв аймгийн Баян, Сэргэлэн, Баянцагаан суманд тархуухан сууж байна⁵.

Монгол хэлэнд, онгон үсийг дайр үс гэдэг байсан бололтой. XII зууны эцэс, XIII зууны эхэн үед Орхон Сэлэнгийн бэлчир хавиар нутаглаж агсан гурван мэргэдийн Увас мэргэдийн тэргүүн Дайр үсүн гэдэг хүн байсан билээ. Ш.Гаадамба эл дайр (dayir, daig) хэмээх үг нь онгон гэсэн утгатай байж болно гэжээ⁶. Л.Болд "Монголын нууц товчоо"-нд гардаг дайр этүгэн, дайр бор хоёр хүлэг хэмээх хэллэгийн дайр хэмээх нь хар хүрэн, хүрэн гэсэн өнгө заасан үг бололтой гэсэн байна⁷. Дайр буга гэж халиун бугыг хэлдэг. Хүний толгойн хүрэн шаргал, цагаан үсийг онгон үс гэх бөгөөд түүнийг хамаа бус таслах, тайрахаас болгоомжилдог.

Дайр гэдэг нь угтаа бор, хүрэн гэсэн утгатай үг байгаад, яваандаа утга нь салаалан, онгон үсийг бас заадаг болсон байж болно. Чингэвэл дайртан нь онгон үстэн гэсэн утгатай байж болно. Тийм онгон үстэй хүний үр саднаас дайртан овог үүсвэрлэсэн буюу эл овгийнхны дотор онгон үстэн байснаас уг овгийн нэр үүдсэн гэмээр санагдана. Дайртан нар монголчуудын дунд олон газар тархан суурьшсанаас үзвэл, энэ овог нэлээд эртхэн буй болсон, хүн амын хувьд цөөнгүй нь харагдана.

Хардал. XX зууны эхэн үед Сэцэн хан аймгийн Илдэн засгийн хошуу (Дорнод аймгийн Халх гол сум)-нд Хардал овогтой, урианхан ястай өрх 5, хардал овогтой хун Зэлмэ ястай өрх 2, хардал овогтой, хиад ястай өрх 1, хардал овогтой цахар ястай өрх 2, гал овогтой, хардал ястай өрх 6, боржигин овогтой хардал ястай өрх 18 өрх, хардал овогтой, урианхай зэлмэ ястай 5 өрх, урианхан овогтой хардал ястай 14 өрх, хун зэлмэ овогтой хардал ястай 2 өрх, хэдэгэйд овогтой, хардал ястай 1 өрх, өөлд овогтой, хардал ястай өрх 1, өрх, цахар овогтой, хардал ястай өрх 1, хандгай овогтой хардал ястай 1 өрх, мөн аймгийн Дайчин засгийн хошуу (Хэнтий аймгийн Батноров сум, Бэрхийн хороо захиргаа бүхэлдээ, Норовлин сумын баруун өмнөд хэсэг)-нд урианхан овогтой хардал ястай өрх 28, мөн аймгийн Эрдэнэ засгийн хошуу(Сүхбаатар аймгийн Мөнххаан сум бүхэлдээ, Уулбаян сумын зүүн тал)-нд хардал овогтой өрх 20 байжээ⁸. Мөн Сэцэн хан аймгийн Бишрэлт засгийн хошуу (Хэнтий аймгийн Галшар сум)-нд их хардал, бага хардал хэмээх хоёр отог байв. Энэ хошуунд хардал овогтон олон байснаас уг хошууны ноён Пүрэвжав (1884-1909)-ыг Хардал жанжин бэйс хэмээн дуудах нь байв.

Бидний хээрийн судалгааны явцад, Булган аймгийн Бүрэгхангай; Хэнтий аймгийн Жаргалтхаан, Дэлгэрхаан суманд хардал мэргэд; Дорнод аймгийн Матад, Чойбалсан, Булган, Баянтүмэн; Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Түмэнцогт; Хэнтий аймгийн Баяновоо суманд хардал; Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд харидал овогтон байгаа нь мэдэгдсэн юм⁹. Дээр дурдсанаас үзвэл, хардал нар нь монголын зүүн зүгийн нутгуудаар голлон тархсан байна. Тэдний тоо цөөнгүй бөгөөд боржигин, урианхан, хиад, хун зэлмэ, цахар, өөлд, мэргэд овогтонтой голлон хамт сууж холилджээ.

Хардал овгийн нэрний үүслийн талаар гурван зүйл домог бидэнд олдсон юм.

Агуулга нь а/. Хардал нарын дээд өвгийн нэгэн ноёны дал нь хар үстэй байсан. Түүнийг хар дал гэж хочлон нэрлэснээс хардал нэр үүссэн юм гэнэ билээ. Энэ домог нь хар дал хэмээх хоёр үг нийлж хэвшээд хардал болсон гэсэн санааг илтгэж байна.

б/. Хардал овогтны дээд өвөг нь хүзүү сээрээрээ хар үстэй хүн байсан. Түүнийг хар дэл хэмээн хочилдог байсан нь хардал болсон юм хэмээнэ. Энд хар дэл гэсэн хоёр үгнээс хардал нэр үүссэн хэмээжээ.

в/. Эрт цагт хариас нэгэн хүн манайхны дотор орж ирснийг харь тал гэж байсан нь хардал болсон. Хардал нар тэр хүний үр саднаас үүссэн юм гэнэ лээ хэмээн эл овгийн настан хуучилна. Энд хари, тал гэсэн хоёр үг хардал болсон гэсэн санаа илэрч байна. Эл овгийн настан нар хардал нэрийн үүслийн тухай дээрх аман домгийг бидэнд мэдээлэв. Эртний монголчуудын ураг барилдах ёсонд хүргэний талыг хари, хүүхний талыг шири хэмээдэг байсан гэж эрдэмтэн Д.Гонгор өгүүлсэн байна¹⁰.

Гуравдахь домогт өгүүлсэн хари тал гэсэн хоёр үг хардал болсон гэдэг санаа монголчуудын эртний ураг хуримын ёс, түүний нэр томъёотой авцалдах төлөвтэй байна. Хардал хэмээх нэрийг зарим тохиолдолд, харидал гэдгийг дээр өгүүлсэн. Энэ харидал нь хардал гэдгийн түрүүчийн хэлбэр буюу дуудлага байж болно.

Юун атугай ч хардал овгийн тоо, тархац, бусад олон овогтой холбогдсон байдлаас үзвэл, тэр нь нь нилээд эрт үүссэн, томхон овог болох нь мэдэгдэж байна.

Таганагад. XX зууны эхэн үед Сэцэн хан аймгийн Илдэн засгийн хошуу (Дорнод аймгийн Халхгол сум)-нд таганагад овогтой, урианхан ястай 2 өрх, таганагад овогтой, урианхан зэлмэ ястай 52 өрх байжээ¹¹. Зарим судлаач Дорнод аймгийн Халхгол суманд далан даганагад хэмээх овог буй¹² хэмээн мэдээлсэн нь дээр дурдсан таганагад мөн буй заа. Монгол нутагт өөр газар эл овог илэрч мэдэгдсэн зүйлгүй. Энэ овгийн нэр XV зууны дунд үеийн хэрэг явдалтай холбогдон, түүхэнд анх удаа тэмдэглэгдсэн байна. Монгол сурвалж бичигт өгүүлснээр, Баянмөнх болох жононгийн хүү Батмөнх багадаа эцэг эхээс хагацан, зүдэж явахад нь Тангнагас (Tangnagas)-ын Төлгэрийн Төмөр хадаг нэрт хүн түүнийг гэртээ авчирчээ. Тэр үед Батмөнх бэтэг өвчинтэй бөгөөд Төмөрхадагийн эхнэр цагаан тэмээний сүүгээр мөнгөн аяга цоортол түүний гэдсийг илж эдгээсний дараа Батмөнхийг Мандухай сэцэн хатанд хүргэж өгчээ¹³. Батмөнх даян хаан ачийг санаж, хожим нь Төмөрхадагийг дархлан, жуух, алтан тамга олгож байжээ. Мөн Тангнагасын Айнтөмөр хэмээх хүн Батмөнх багадаа Хулгарын голын усанд унасанд мөн туслан аварчээ.

Тангнагас овгийнхон тийнхүү XV зууны үед Монголын алтан ургийн хаад, ноёдод ойр дөт явж, тэдэнд үйлчлэн тусалж байсан аж. Дээр өгүүлсэн тангнагас нь хожмын таганагад овог мөн болно. Эл хоёр нэрийн сүүлчийн –с- ба –д- нь олны нөхцөл юм. Тангнагад буюу таганагад хэмээх нэр нь угтаа монгол хэлний **тагнах** хэмээх үгтэй язгуур нэгтэй бололтой. Монгол хэлний тагнах хэмээх үг нь эрт цагт тангнах гэгдэж байснаа хэлний хөгжлийн явцад хувираад, өдгөө тагнах болсон. Иймэрхүү авиа тонгорон үгийн бүтэц хувирсан баримт цөөнгүй буй. Үүнд,

Ангнах (angnaqu)-агнах

Дангнах (dangnaqu)-дагнах

Дүнгнэх (düngnequ)-дүгнэх

Шангнах (sangnaqu)-шагнах гэх мэтийг дурдаж болно.

Тэгэхээр урьдын тангнагас нь дээр өгүүлснээр өдгөө таганагас буюу таганагад болсон байна. Энэ дашрамд тэмдэглэхэд, монгол хэлний чагнах, тагнах хоёр нь угтаа язгуур нэгтэй бөгөөд хөгжлийн явцад хэлбэр болоод утга хувирсаар өдгөө хоёр өөр үг болсон. Тийнхүү өдгөөгийн тагнагад хэмээх овгийн нэр нь чагнах буюу тагнах хэмээх үгээс ирэлтэй гэлтэй. Эл овгийн нэр нь тэдний өвөг дээдсийн гүйцэтгэж явсан ажил үүргийг тусгасан байж мэднэ. Харин зарим бичиг зохиолд, **танглахар**¹⁴ (tanglayar), **тангара**¹⁵ (tanggara) хэмээх угсаатны нэр гардаг нь таганагад (tangnaγad)-ын хазгай бичлэг юм.

Таганагад нь урианхан, хун зэлмэ овогтой ойр төрлийн холбоотой нь түүний яснаас харагдаж байна. Хун зэлмэ нь жарчиуд аданхан урианханы Зэлмэ жанжны үр удам, харьяатын үржвэрээс буй болсон билээ.

Жируган (жороон, жорон, зургаан). XX зууны эхэн үед Сэцэн хан аймгийн Эрдэнэ засгийн хошуу (Дорнод аймгийн Цагаан-Овоо сум бүгд, Баян-Уул, Баяндун сумын өмнөд, Баянтүмэн сумын баруун хэсэг)-нд жируган овогтой 27 өрх байжээ¹⁶. Мөн бидний хээрийн судалгааны явцад Булган аймгийн Бугат; Дорнод аймгийн Баянтүмэн; Төв аймгийн Мөнгөнморьт, Эрдэнэ, Баяндэлгэр, Баян, Алтанбулаг, Баянцогт; Хэнтий аймгийн Дадал, Норовлин, Дэлгэрхаан суманд жороон, жорон овог байгаа нь илэрч мэдэгдэв¹⁷.

Жируган гэдэг нь жороон гэдэг үгийн эртний бичлэг, дуудлага юм. Жорооныг бас зарим нутагт жорон хэмээдэг байна. Зарим бичиг зохиолд буй жируган гэдэг угсаатны нэрийг өнөөгийн хэллэгт буулгахдаа, зургаан, зорогон хэмээн хазгай тэмдэглэснээс зоргоон буюу зургаан гэх нэр буй болжээ.

Жируган буюу жороон нь угтаа хори буриад, барга нарын дотор байдаг үржвэр овгийн нэр. Зарим нутагт,

Жорон жорон жороохой

Жоронгийн бөгс эрээхэй хэмээн тэднийг хочилдог байна¹⁸.

Жируган, жорон нь монгол хэлний жороо хэмээх үгээс үүсэлтэй юм.

Дураал нь ноёдын цол чимгээс үүсэлтэй овгийн нэр. Дорноговь аймгийн Даланжаргалан, Иххэт, Айраг, Алтанширээ сум, Говьсүмбэр аймагт эл овог буй¹⁹.

XVI-XVII зууны үед Монголын зарим ноёд, язгууртан нар **дураал** хэмээх цол чимэг хэрэглэдэг байжээ. Халхын ноёдын дээд өвөг Гэрсэнз (1513-1549)-ийн дөтгөөр хүү Амин **дураал**²⁰, Дарайсун Гүдэн хааны дэд хүү Дураал ноён²¹ гэж явжээ. Дураал нь монгол ноёдын цол байснаа зарим ноёд тэр цолоороо дуудагдах болсноор хүний нэр мэт болсон нь тааралдана.

XVII-XVIII зууны үеийн монгол сурвалж бичгүүдэд, өнөөгийн дураал хэмээх үгийг дураар (*durar*)²², дурагал (*duraḡal*)²³, дурал (*dural*)²⁴ хэмээн янз бүрээр тэмдэглэсэн байна.

Тэрчлэн хоёр зохиолд, нэг хүнийг Буянхули дураар (*durar*)²⁵, Буянхули дурагал (*duraḡal*)²⁶ гэхчлэн өөр өөрөөр бичсэн нь ч тохиолдоно.

Дээрх жишээнээс дураал хэмээх үгийн хувирлыг үзэж болмоор. Уг цол нь анхандаа дура-бар хэмээгддэг байснаа дураар болоод, тэр нь дураал (*dura-bar-duraḡar-duraḡa-dural*) болсон гэлтэй.

Монгол хэлэнд үгийн сүүл хэсэгт дундаа эгшиг жийрэглэж орсон хоёр –р-гийгүүлэгчийн сүүлчийнх нь –л- болох тохиолдол байдаг. Үүнийг

бариур-бариул

харуур-харуул

хайруур-хайруул

хэрүүр-хэрүүл гэх жишээнээс харж болно.

Дээрхийн адилаар **дураар** нь **дураал** болсон бөгөөд тэр нь хуучин бичиг зохиолд хааяа **дурал** хэмээн тэмдэглэгдсэн байна. Дураал овгийн тархацаас үзвэл, Сэцэн хан аймгийн Боржигин сэцэн засаг, Мэргэн засгийн хошууны ноёд, тайж нарын зарим нь дураал цол зүүж явсан нь яваандаа тэдний харьяат нарынх нь овог мэт болсон ажээ.

Дагуур. Булган аймгийн Хутаг-Өндөрт дагуур; Дорнод аймгийн Цагаан-Овоо суманд дагуур барга овогтон буй. Дагуур, дагуур баргын хүн ам нэн цөөн.

Дагуур нь монголчуудтай нийтлэг нэг гаралтай аймаг юм. Түүний нэр түүхэнд анх удаа **Да хэ** хэмээн, VI зууны үед тэмдэглэгджээ. Тэд нэр мэдэгдсэн цагаас хойш өдгөөгийн Их хянган давааны өмнөд хормойн Тоор голоор нутагласаар иржээ.

Да хэ буюу дагуур нар нь анхандаа Хятаны голлох аймгийн нэг нь байв. Түүний язгууртан нар нь VII зууны дундуур Хятан аймгийн тэргүүлэгчээр өргөмжлөгдөн хүчирхэг явжээ. Да хэ нар өсч үржин салбарласаар хожим нь 8 овог болжээ. Ихэнх судлаачид

дагуур хэл нь эртний монгол хэлний нэг салаа гэж үздэг байна. Дагуур аймгийн эртний нэр Да хэ нь Тоор голын нэрээс үүдэлтэй гэж Японы эрдэмтэн К.Ширатори нотолсон байна. Монголын Түмэн засагт хаан (1539-1592) зөрчид, дагуур нарт довтлон, татлага авахыг оролдож байжээ. XVII-XVIII зууны эхэн үед барга(буриад)-ын зарим нь Чичигаар, Их Хянганы хавиар нутаглаж явахдаа, дагуур нартай харилцаж, зарим талаар холилдсон байна. Дээрх дагуур, дагуур барга овог нь Хятаны голлох Да хэ буюу дагуур аймгийн үр хойчисын удам мөн буй заа.

Цагаан гэрүүд (гэрүүд). Дорнод аймгийн Матад, Халх гол; Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Онгон, Дарьганга, Наран, Асгат; Сэлэнгэ аймгийн Түшиг, Цагааннуур, Алтанбулаг суманд буй²⁷.

Цагаан гэрүүд, гэрүүд овог нь угтаа тахилга, тайлга эрхлэгчдээс буй болсон бололтой. Урьд монголчууд өвөг дээдэс, бусад хүндтэй хүмүүсийг нас барсных нь дараа тэдний сүнс сүлдэнд зориулсан тайлга хийдэг байв. Аливаа хүний сүнс сүлдэнд зориулсан тахилгын хамгийн эрхэм зүйл нь **өвхий** юм. Цагаан тэмээний толгойн орой дахь ноосыг аваад, нас барж хүний ам, хамар дээр тавьдаг. Тэгээд нас барагчийн сүүлчийн амьсгалыг уг ноосонд шингэн үлдсэн хэмээн ойлгож, монголчууд түүнийг өвхий хэмээн нэрлээд тахидаг байжээ. Тахилгын гэрт өвхийгээс гадна тухайн нас барсан хүний хувцас хунар, бусад эдэлж хэрэглэж агсан зүйлс бас хадгалагддаг байв. Тийм тахилга XX зуунаас өмнө Монгол нутгийн цөөнгүй газарт байсан аж. Өвөг дээдсийн сүнс сүлдэнд зориулсан тайлгыг их төлөв тусгайлан бэлтгэсэн цагаан эсгий гэрт хийдэг.

Тайлгын тэр гэрийн бүрээсийг 3 жилд нэг удаа шинэтгэн, цагаан эсгийгээр бүрдэг. Тайлгын гэрүүдийг арчлан хамгаалж, жилийн тогтсон мөчлөгт тахилгын ёсыг эрхлэн гүйцэтгэгчдийн тэргүүнийг цагаан гэрийн ноён, цагаан гэрийнхэн хэмээдэг байж. Тэр цагаан гэрийнхэн гэдэг нь яваандаа цагаан гэрүүд, гэрүүд болсон бололтой. Монголын нутаг нутагт тайлгын гэрүүдийг арчлан ёс төрийг гүйцэтгэгчид нь бүгд нэг овгоос гаралтай байгаагүй нь мэдээж. Тэд янз бүрийн овгоос бие гарагсад байж таарна. Энд нэг баримт дурдвал, 1918 онд Сэцэн хан аймгийн Илдэн засгийн хошуунд зэлмэн ястай, гэрүүд овогтой өрх 3, гэрүүд ястай, хөхнүүд овогтой өрх 1, хун зэлмэ ястай, гэрүүд овогтой өрх 1, гэрүүд овогтой, ханхатнууд ястай өрх 4, гэрүүд овогтой урианхан ястай 6 өрх²⁸ байсан нь дансанд тэмдэглэгдсэн байна. Эндээс зөвхөн Илдэн засгийн хошууны гэрүүд нь уг гарлаараа урианхан, зэлмэ, хөхнүүд, ханхатнууд овогтой холбоотой нь мэдэгдэж байна.

Жонгоор. Архангай аймгийн Жаргалант, Цэцэрлэг суманд эл овог буй нь бидний хээрийн судалгааны явцад илэрч мэдэгдсэн юм²⁹. Жонгоор гэдэг нь угтаа *Зүүнгар* гэсэн үгийн хазгай дуудлага болно. Жонгоор овогт настны өгүүлснээр бол, тэд угтаа Амарсанаагийн хойдуудын тасархай гэнэ. Ойрадын Зүүнгар хаант улсын нэрээр тэднийг анхандаа Зүүнгар хэмээж байснаас яваандаа жонгоор болон сунжирсан байна. Эл овгийн хүн ам цөөвтөр аж.

Аруд. Хэнтий аймгийн Норовлин, Баян-Адрага, Батноров суманд буй хүн ам олонгүй овог³⁰. Аруд овог нь арулад аймгийн үр хойчис байж магадгүй. Түүхэн домгоор бол, арулад нь эрт цагт Эргунь-кунгаас гарч ирсэн монгол аймгуудын дотор байлцсан аймаг. Тэгээд ч арулад нар язгуурын монголчуудын дарлигины бөлгийн арван найман овгийн нэг гэгдэж явжээ.

Түүхэн домогт, уряуд нарын өвөг дэдэст Хонхотон (Конкотан), Арулад (Арулат), Уряуд-килинкут хэмээх ах, дүү гурав байсан. Тэр гурваас дээрх гурван аймаг үүссэн гэнэ³¹. Арулад нь тэдний дундах нь байсан бөгөөд түүний үр саднаас арулад аймгийнхан буй болжээ. "Монголын нууц товчоо" –нд, Хайдугийн отгон хүү Чаожин Өртөгтэйгийн 3 хүүгийн нэгээс нь **арула(+д)** овогтон үүссэн гэжээ. Зарим мэдээгээр, Хайду нь 1025 оны орчинд төрсөн хүн гэснээс бодвол, түүний ач нарын үүсгэсэн арула(-д) овог нь XI зууны эцсээр буй болсон гэмээр байна.

XII зууны сүүлч үеэр арулад нар Тайчуудын бүрэлдэхүүнд багтан, Ононгийн эхэн урсгал, Хэнтий уулаар нутаглаж явжээ.

Аруладын Боорчи ноён Чингис хааны есөн өрлөгийн нэг гэгдэж явсан бөгөөд XIII зууны хоёрдугаар хагасын дунд үед Чингис хааны онгоныг байгуулахад Боорчийн үр сад түүний тахилга тайлгын зан үйлийг эрхлэн харж хамгаалах үүрэг хүлээжээ. Тэр цагаас Боорчийн үр хойчис нь эзэн хорооны дархадын голлох хэсгийг бүрдүүлснээр өдгөө хүрсэн байна.

Арулад хэмээх нэр нь уулын араар нутаглаж явснаас үүдсэн бололтой гэж Х.Пэрлээ үзсэн байна. Өөрөөр хэлбэл, эл угсаатны нэр нь ар өврийн ар(у) гэдгээс үүссэн, - л -, - д - нь олны нөхцлийг давхар залгасан хэлбэр ажээ. Аруд гэдэг нэр ч мөн л ар(у) дээр олны – д – нөхцөл залгаж бүтээсэн угсаатны нэр гэлтэй.

Отол. Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил суманд нутагласан овог³². Дагуур хэлэнд, ач зээг **отол** хэмээдэг аж³³. Отол овог нь XVIII зууны эхэн хүртэл барга нарын нутаглан сууж агсан Сэцэн хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутагт тааралдаж байна.

Эл барга нар XVII зууны эхнээс Чичигар орчмоор нутаглан, дагуур нартай ойр харилцаж явсан билээ. Тэр цагт уг барга нарын дотор дагуур хүмүүс орсон нь өдгөөгийн отол овогтон байж болно. Иймд бид отол нь дагуур гаралтай, халхжсан овог гэж үзэж байна. Отол нь урьдын Боржигин сэцэн засгийн хошууны баруун хэсгээр тархан нутагшижээ.

Нирун. 1924 онд болсон Монгол улсын анхдугаар их хуралд тэр үеийн Цэцэрлэг мандал уулын аймгийн Алдархаан уулын хошууны Бадрах сумын Ханнуур багаас 33 настай малчин, нирун овогт Аюурын Эриндаваа, мөн аймгийн Шашинбат Сэвжид уулын хошууны Уран мандал сумын харьяат бөгөөд тэр үед Улиастайн сайдын тамга хамаарагч 39 настай, нирун хиан овогт Тулгатын Банзрагч нар сонгогдон, төлөөлөгчөөр оролцсон байна³⁴. Мөн үеийн Богд хан уулын аймгийн Богд хан уулын хошууны Эрдэнэ уулын сумаас цагдаа сэргийлэхэд бичээч, нурун овогт 53 настай Цэдэндамбын Дамдинжав уг их хуралд бас оролцжээ³⁵. Алдархаан уулын хошууг анх 1922 онд Дашпунцаглин хийдийн харьяат шавь нар болон Яруугийн хүрээний ойролцоох өртөөний болон цагдаа цэргийн албанд сууж байгсдаар байгуулсан ажээ.

Харин Цэцэрлэг мандал аймгийн Шашинбат Сэвжид уулын хошуу нь урьдын Сайн ноён аймгийн Баатар засгийн хошуу буюу одоогийн Завхан аймгийн Булнай (Тосонцэнгэл) сумын нутаг болой. Тэр үеийн Богд хан уулын аймгийн Богд хан уулын хошууны Эрдэнэ сум нь өнөөгийн Төв аймгийн Эрдэнэ сум юм. Чингэхүл, дээрх нутгуудад XX зууны эхээр нирун, нирун хиан, нурун овогт монголчууд сууж байжээ.

Түүхэн домогт өгүүлснээр, Добу мэргэнийг амьд сэрүүн байхад, түүний хатан Алунгоогоос төрсөн Бэлгүнүтэй, Бүгүнүтэй хоёр хүүгийн харьяат аймгийг ерөнхийд Дарлигин (Дэрлэгин) хэмээдэг. Харин Добу мэргэнийг нас нөгчсөний дараа бэлбэсэн үлдсэн Алунгоогоос төрсөн Буха Хатаги, Бугуту Салжи, Бодончар мунхаг (монхан) гурван болоод тэдний харьяат аймгийг нийтэд нь Нирун хэмээн нэрлэдэг байжээ.

Добу мэргэнийг нас нөгчсөний дараа Алунгоо хатны өргөө гэрт “шөнө бүр гэгээн шар хүн гэрийн өрх тотгын гэгээгээр орж, Алунгоо хатны хэвлийг илж, гэгээ нь хэвэл дотор шингэх бөлгөө. Гарах наран, сарын хилээр тэр шар хүн шар нохой мэт шазвалзаж гарах билээ. Түүгээр ухваас (үзвээс), тэмдэг нь (Буха Хатаги, Бугуту Салжи, Бодончар нар) тэнгэрийн хөвүүд буй заа” хэмээдэг³⁶. Өөрөөр хэлбэл, бутач Буха хатаги, Бугуту Салжи, Бодончар мунхаг гурвын эх Алунгоо гэрлээс жирэмсэлжээ. Тэгээд тэднийг ёст газраараа биш, харин нуруунаасаа төрүүлсэн хэмээн домоглоно. Тийнхүү тэд эхийнхээ нуруунаас төрсөн учир нирун нэр зүүсэн гэнэ³⁷. Нирун гэдэг нь нуруун гэсэн монгол үгийн дундад эртний дуудлага юм. Уг үгийн авианы хувьслыг үзүүлвэл; niɣuːɣun → niɣun → niɣun болсон мэт.

Пэрс сурвалжийн мэдээгээр бол, XII зууны үед Нирун аймгийн бүрэлдэхүүнд катакин (хатагин), салджиут (салжиуд), тайджиут (тайчууд), хартакан, сиджиут (шижүүд), чинос (чонос), нукуз (нохос), нуякин (ноёхон), урут (урууд), мангут (мангууд), дурбан (дөрвөн), баарин, барулас, хадаркин (хадархин), джуръяат, будат, дуклат, ийсут (бэсүд), сукан (сухан), кингиат зэрэг 16 аймаг багтдаг байжээ³⁸. Тэр үед Нирун нарыг бас Кият

(хиад) хэмээн нэрлэдэг. Хиад нь дотроо бас юркин (зүрхэн), чаншиут, кият-ясар хийгээд хиад боржигин хэмээн хоёр салаа болдог байсан гэнэ³⁹.

Язгуурын монголчуудын Нируны салбарт багтаж, Алунгоо хатны сүүлчийн гурван хүү, тэдний үр садад захирагдаж явсан дээрх овог аймгуудын зарим нь хожмын монголчуудын бүрэлдэхүүнд орж, тоонд нь багталцжээ. Тэгэхдээ, тэд эртний овог аймгуудын нэгтгэлийн нирун хэмээх нэрийг зүүж явсаар халхчуудын угсаа соёлын хөгжилд оролцсон ажээ.

Монголчуудын бүрэлдэхүүнд явсан нирун нар XVIII зууны эхэн үеэс өмнө Зүүн Сибирийн зарим газарт очиж нутаглан суугаад, очсон газрынхаа түнгүс, түрэг угсаатны аймаг, овгуудын нөлөөнд орж, өөрийн хэл, соёлын зүйлээ гэж харьжсан байна.

Зарим баримтаас үзвэл, XIX зууны сүүл үед, Читийн тойрогт Нирун 224 хүн бүртгэгдсэн байна⁴⁰. Мөн энэ тойрогт Нирун нартай ойролцоо газарт Мунгал (Монгол), Сортот (Сартууд буюу Сартуул), Сухан, Тугчин зэрэг монголчуудын дотор тохиолддог овог ч бас байжээ⁴¹. Читийн тойргийн тэрхүү нирун нар тухайн үед түнгүс хэлээр ярьдаг болчихоод байсан ажээ. Мөн Нерчүүгийн тойрогт, XIX зууны үед Түнгүсийн Дулакагир нарын дотор Нерон, Сухан овог багтаж явжээ. Тэд еер еерсдийн овгоороо тус бүр нэгжгээд засаг захиргааны бага нэгж байгуулж явсан гэнэ⁴².

“Монголын нууц товчоо” зэрэг монгол сурвалж бичгүүд хийгээд нангиад түүх шастирт, нирун хэмээх угсаатны нэр тэмдэглэгдсэн нь энэ хэр илэрч мэдэгдсэн зүйлгүй. Тэгээд ч зарим судлаач нирун нэрт угсаатны бүлэг байсан, эсэх тухай эргэлздэг байна. Гэтэл XX зууны эхэн үед халхчуудын дотор нирун, нирун хиан, нурун (нуруун) хэмээх овог байсныг баримтаар илрүүлсэн нь тэр эргэлзээг арилгаж, язгуурын монголчуудын дотор эрт цагт Нирун хэмээх нэртэй угсаатны бүлэг байсныг хөтөлбөргүй нотолж байна.

“ About the origin of some Mongolian tribe names, scattering”.

Summary

By A. Ochir.

The author studied diffusion, geneology and ethnonyms of the some Mongolian abundant clans and draws following conclusions: For example, Onniud clan originated from descendents of Otchigin and Hachiun, they were brothers of Chinggis khan. The tribes name was begun words as: wang-nuᠯud. Taganagad clan's name originated from Mongolian words: tangnaqu. Duraal clan originated from the words duragal, which was Mongolian aristocrat's title of XVI-XVII centuries.

Эшилсэн ном зохиол

- ¹ Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас УБ., 1979 тал.57.
-- С.Пүрэвжав. Хотгойдын угсаа гарал ба түүхийн асуудалд (XVI-XIX зуун). УБ., 1970. тал.29.
-- Тайжиуд Аюудайн Очир. Бэсүд Жамбалдоржийн Сэржээ. Монголчуудын овгийн лавлах. УБ., 1998. тал.18-26; 30-33.
- ² Рашид-ад-дин. Сборник летописей. Том-1. кн-2. М-Л., 1952. стр.247.
- ³ Шара туджи. Монгольская летопись XVII века. М; 1957. стр.95.
--Алтан хүрдэн мянган хэгээст. Чойжи тулган харьцуулж тайлбарлав. ӨМАХХ. 1987. тал.78.
- ⁴ А.Очир. Урианхай нарын угсаа-түүхийн асуудал-"Түүхийн судлал" Том-XXXII, Fasc-2, УБ., 2000. тал.23.
- ⁵ Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас. УБ., 1979. тал.61.
- Тайжиуд Аюудайн Очир. Бэсүд Жамбалдоржийн Сэржээ. Монголчуудын овгийн лавлах. УБ., 1998. тал.10-11; 14-15; 27-29; 38-39; 47-48
- ⁶ Ш.Гаадамба. Монголын нууц товчоо. УБ., 1990. тал.289.
- ⁷ Л.Болд. «МНТ»-ны зарим үгийн гарлыг Орхон бичгийн дурсгалаас сурвалжлах нь-"Монгол, Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээ-4" Сеул., 1996. тал 410.
- ⁸ Монгол Улсын Үндэсний Төв Архив (Хойшид МУУТА гэж товчилно.). ФА-34; т-1. хн-137; ФА-34; т-1. хн-135; ФА-34; т-1. хн-132; ФА-34; т-1. хн-133; ФА-75; д-1. хн-20;
- ⁹ Тайжиуд Аюудайн Очир. Бэсүд Жамбалдоржийн Сэржээ. Монголчуудын овгийн лавлах. УБ., 1998. тал 14-15; 20-24; 34-37; 49-50.
- ¹⁰ Д.Гонгор. Халх товчоон. УБ., II боть. 1978. тал 110-120.
- ¹¹ МУТТА. ФА-34, Т-1, ХН-134; ФА-34, Т-1, ХН-133; ФА-34, Т-1, ХН-140.
- ¹² Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас. УБ., 1979. тал 75.
- ¹³ Gad-un ündüsün quriyangui Altan tobci. Тэргүүн дэвтэр. Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн, эх бичгийн судалгаа хийсэн Шаравын Чоймаа. УБ., 2002. тал 90-92; 320-322.
- ¹⁴ Sagan Secen. Erdeni-yin tobci. (precious summary). A Mongolian chronicle. I. of 1662. The Urga text transcribed and edited by M.Go, I. de Rachewiltz, J.R.Kruger and B.Ulaan. The Australian National University. 1990. p-137.
- ¹⁵ Дарма. Алтан хүрдэн мянган хигээст. ӨМАХХ. 1987. тал 141.
- ¹⁶ МУТТА. ФА-75, Д-1, ХН-20.
- ¹⁷ Тайжиуд Аюудайн Очир, Бэсүд Жамбалдоржийн Сэржээ. Монголчуудын овгийн лавлах. УБ., 1998. тал 14-15; 20-24; 38-39; 49-50.
- ¹⁸ Монгол улсын угсаатны зүй. III боть. УБ., 1996. тал 93.
- ¹⁹ Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас. УБ., 1979. тал 53.
-Тайжиуд Аюудайн Очир, Бэсүд Жамбалдоржийн Сэржээ. Монголчуудын овгийн лавлах. УБ., 1998. тал 18-19.
- ²⁰ Асрагч нэртийн түүх. Х.Пэрлээ хэвлэлд бэлтгэв. УБ., 1960. тал 73.
- ²¹ Hans-Peter Vietze, Gendeng Lubsang. Altan Tobci. Text und index. Tokyo. 1992. p-117.
- ²² Sagan Secen. Erdeni-yin tobci. (precious summary). 1990. p-137.
- ²³ Byamba-yin Asarayci neretu (yin) teuke. Тэргүүн дэвтэр. Галиглаж үгийн хэлхээг үйлдэн хэвлэлд бэлтгэсэн Цэвэлийн Шагдарсүрэн, И Сөн Гю (Lee Seong Gyu). УБ., 2002. тал 266-267, 270, 272-273, 276, 278-279, 282.
- ²⁴ Hans-Peter Vietze, Gendeng Lubsang Altan tobci. p-117.
- ²⁵ Sagan Secen. Erdeni-yin tobci. (precious summary). 1990. p-137.
- ²⁶ Byamba-yin Asarayci neretu (yin) teuke. Тэргүүн дэвтэр. Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн хэвлэлд бэлтгэсэн Цэвэлийн Шагдарсүрэн, И Сөн Гю (Lee Seong Gyu). УБ., 2002. тал 266-267.
- ²⁷ Тайжиуд Аюудайн Очир, Бэсүд Жамбалдоржийн Сэржээ. Монголчуудын овгийн лавлах. УБ., 1998.тал 20-24.
- ²⁸ МУУТА. ФА-34, Т-1, Хн-133, 134, 135, 136, 137.

- ²⁹ Тайжиуд Аюудайн Очир. Бэсүд Жамбалдоржийн Сэржээ. Монголчуудын овгийн лавлах. УБ., 1998. тал 10-11.
- ³⁰ Тайжиуд Аюудайн Очир. Бэсүд Жамбалдоржийн Сэржээ. Монголчуудын овгийн лавлах. УБ., 1998. тал 49-50.
- ³¹ Рашид-ад-дин. Сборник летописей. т-I, кн-1. М-Л., 1952. стр 166.
- ³² Тайжиуд Аюудайн Очир. Бэсүд Жамбалдоржийн Сэржээ. Монголчуудын овгийн лавлах. УБ., 1998. тал 25-26.
- ³³ Elizabeth. E.Bacon. Obok. A study of social structure in Asia. New-York. 1958. p-97-98; 116.
- ³⁴ МУУТА. Ф-2; Т-47; 2-1-86; ХН-1.
- ³⁵ МУУТА. Ф-4; Т-2; ХН-116.
- ³⁶ Word and suffix-index to the Secret History of the Mongols. Based on the Romanized transcription of L.Ligetii. Compiled by H.Kuribayashi and Choijinjab. Sendai. 2001. § 20-21. p.18.
- ³⁷ Рашид-ад-дин. Сборник летописей. Том-I. КН-II. М-Л., 1952. стр.10-12.
- ³⁸ Мөн тэнд. стр-78.
- ³⁹ Мөн тэнд. стр.79.
- ⁴⁰ С.Патканов. Статические данные, показывающие племенной состав населения Сибири: Языки и роды инородцев. Том-I, СПб., 1911. стр.560.
- ⁴¹ Мөн тэнд.
- ⁴² Б.О Долгих. Родовой и племенной состав народов Сибири в XVII в. М., 1960. стр.341.